

Төсөл бичих зөвлөмж

Хэрэв та төслийн зээл авахаар төлөвлөж байгаа бол бидний өгөх зөвлөгөөнд анхаарлаа хандуулна уу.

1. Мөрөөдөлдөө биш бодит байдалд түшиглэн бич. Төсөл бичихийн тулд хүмүүс ихэвчлэн тэгнэ ингэнэ гэсэн мөрөөдөл маягийн зүйлүүдээ өгүүлбэрт оруулаад биччихдэг. Гэтэл төсөл нь өөрөө тодорхой судалгаа, бодит тооцоолол дээр үндэслэсэн байх шаардлагатай байдаг. Шинээр бүтээгдэхүүн хийх гэж байгаа тохиолдолд тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхтэй холбоотойгоор ямар ямар зардлууд гардаг, тухайн чиглэлийн үйлдвэрлэл явуулахад ямар ямар бэрхшээл гардаг гэх мэт судалгааг зах зээл дээр тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бодит үйлдвэр дээр түшиглэн хийх нь зүйтэй. Учир нь ялангуяа үйлдвэрлэл явуулна гэдэг бол өөрөө маш олон төрлийн бэрхшээлтэй тулгарч байдаг тул энэ нь илүү үнэн бодитой болно. Тиймээс бүх зүйлийг анхнаас нь нарийн тооцоолж төлөвлөж байх хэрэгтэй.

2. Бодит тоон тооцооллыг сайн оруулж өг. Жишээ нь маркетингийн төлөвлөгөө гэхээр зөвхөн бид ингэж реклам цацна, тэгж урамшуулал зарлана гээд бичээд ирдэг. Гэтэл үүний цаана ямар зардал гарч байгаа талаар тодорхой ойлголтгүй явж байдаг. Угтаа бол рекламаа явуулахын тулд реклам хийдэг газруудын үнэ өртөгт судалгаа хийж тэр дундаасаа алиныг нь сонгохоо ч тодорхойлсон байх хэрэгтэй. Жишээлбэл телевизээр реклам явуулахаар бол телевиз бүрийн нэг минутын рекламны үнэ өртгийг судалж үүнтэй холбоотойгоор рекламны зардлаа төлөвлөсөн байх хэрэгтэй.

3. Тооцооллуудаа баталгаажуул. Дээрх хийсэн тооцооллууд нь тодорхой баримт, нотолгоогоор баталгаажсан байх хэрэгтэй. Жишээ нь: тоног төхөөрөмж худалдан авах өртгөө нийлүүлэгч компаниас ирсэн үнийн саналаар баталгаажуулах байх гэх мэт.

4. Үйлдвэрлэлийн төлөвлөгөөндөө сайн тооцоолол хий. Манай бизнес эрхлэгчид ихэвчлэн маш өндөр хүчин чадалтай, маш том хэмжээний тоног төхөөрөмж авахаар төсөл хийж ирдэг. Гэтэл яг үйлдвэрлээд зах зээл дээр бүтээгдэхүүнээ нийлүүлээд ирэхээр нөгөө тоног төхөөрөмжийнхөө хүчин чадлын 50 хүрэхгүй хувийг ашиглаж байдаг. Энэ нь нөгөө их өндөр үнэ өртөгтэй тоног төхөөрөмжийнхөө ашгийг гаргаж чадахгүй байгаа төдийгүй, хөрөнгөө түгжиж байна гэсэн үг юм. Гэтэл тэр тоног төхөөрөмжийг ажиллуулахтай холбоотой гарах зардлууд гарсаар л байдаг. Ингээд эцэст нь үйлдвэрлэгчид маань зардлаа даахгүй сөхрөх магадлал өндөр болдог. Тиймээс бизнес эрхлэгчид маань эхний ээлжинд юу хийх вэ, яаж хийх вэ, ямар хэмжээгээр хийх вэ, яаж борлуулах вэ гэдэг асуултуудад маш тодорхой нарийн тооцоололтойгоор хариулт өгсөн байх ёстой юм.

5. Багаа бүрдүүл. Төслийг хэрэгжүүлэх маш сайн менежментийн баг бүрдүүлэх хэрэгтэй. Жишээлбэл А компани хэвлэлийн үйлдвэрлэл эрхэлдэг байя гэж бодъё. Компанийн захирал нь 10 жил хэвлэх үйлдвэрт ажилласан туршлагатай хүн байг. Гэвч энэ хүнд компанийг удирдан зохион байгуулах ямар нэгэн дадлага туршлага байхгүй. Тэгвэл энэ хүнд тухайн компанийг нь удирдаад авч явж чадах менежментийн мэргэшсэн баг байх хэрэгтэй. Ингэвэл сая тэр хүн үйлдвэрлэл, удирдлага хоёрыг зөв хослуулж чадах юм.

6. Зах зээлээ мэдэрч хөгж. Аливаа бизнесийн байгууллага нь цаг хугацааны явцад байнга өсөн нэмэгдэж байх нь тухайн байгууллагын хувьд хөгжлийн зөв голдрил болж өгдөг. Гэтэл манай бизнес эрхлэгчид өнөөдөр 10.0 сая төгрөгийн бизнес хийдэг байж байгаад маргааш гэнэт 500.0 сая төгрөгийн бизнес эрхлэх гэж зүтгэдэг. Гэтэл энэ нь зах зээлийнхээ хуулийн дагуу өсөж байгаа биш, зохиомол өсөлтүүсгэж байгаа хэлбэр юм. Тиймээс зах зээлийнхээ эрэлт нийлүүлэлтийг харж, судлаад зөв хөдлөх хэрэгтэй юм.

Төслийн баримт бичиг доор дурьдсан бүтэцтэй байх бөгөөд хавтаснаас бусдыг нэг тусдаа бүлэг болгон дугаарлах нь зүйтэй.

1. Төслийн баримт бичгийн хавтас. Энэ бол танай байгууллага таны нэрийн хуудас гэсэн үг юм. Иймд анхаарал татахаар байвал зохино.

2. Товч танилцуулга. Энэ бүлэгт төслийн мөн чанар, агуулгыг тодорхой, товч бичих бөгөөд хагас хуудас, дээд тал нь нэг хуудас байвал зохино. Дараахь асуултад хариу өгөхүйц нэгээс хоёр өгүүлбэр байхад хангалттай. Үүнд:

- Төслийг хэн хэрэгжүүлэх вэ?
- Төсөл хэнд, ямар учраас хэрэгтэй вэ?
- Төслөөс ямар үр дүн гарах вэ?
- Төслийг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ?
- Төсөлд хэдий хэр хөрөнгө шаардлагатай вэ?

3. Оршил буюу танилцуулга. Захиалагч байгууллагын тухай мэдээллийг агуулдаг. Үүнд төслийг хэн өгсөн, хэн хэрэгжүүлэх, төсөлд оролцогчид чухам яагаад мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, итгэл үнэмшил, алдар хүндийн хувьд энэ ажлыг бусдаас илүү гүйцэтгэх чадвартай гэж үзэж байгаа тухай өгүүлнэ.

4. Хэрэгцээ шаардлага. Энэ бүлэгт тухайн төслийг ямар шаардлага, хэрэгцээг үндэслэн ямар бэрхшээл, асуудлыг шийдвэрлэхийг зорьсон, энэ нь захиалагч байгууллагын зорилго, зорилттой хэрхэн уялдаж буй тухай өгүүлнэ.

5. Зорилго, зорилт. Хандивлагч энэ бүлгээс төслийн үр дүнгийн тухай тодорхой төсөөлөлтэй болдог. Зорилго нь чухам юуны төлөө энэ төслийг бичив гэдэгт хариу өгөх ёстой. Зорилт бол төслийг хэрэгжүүлэхийн тулд хүрэх тодорхой үр дүн юм. Зорилт, үр дүнг тоон чанараар үнэлдэг.

6. Арга зүй. Энэ бүлэгт төлөвлөсөн үр дүнд хүрэх, бэрхшээл асуудлыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, явуулах үйл ажиллагааг заадаг. Тухайн төслийн зохион байгуулалт, ажлын төлөвлөгөөг энд оруулах ёстой. Мөн энэ хэсэгт чухам юу хийх вэ? хэн, хэзээ хэр хугацаанд энэ ажлыг хэрхэн, ямар дарааллаар гүйцэтгэх вэ, ямар нөөц бололцоог ашиглах вэ гэдгийг ойлгомжтой, тодорхой бичнэ.

7. Үнэлгээ дүгнэлт, тайлан. Энэ бүлэгт төслийг төгсгөлд нь яаж үнэлж, дүгнэх тухай саналаа бичнэ. Үүнд тухайн төсөл зорилгодоо хүрсэн эсэх, төслийн явцад тавих хяналтын аргын тухай өгүүлнэ. Мөн хийсэн ажил, зарцуулсан хөрөнгийн талаарх тайлангаа гаргах тухай дурьдах ёстой.

8. Төслийн баталгаат байдал, дараагийн санхүүжилт. Энэ хэсэгт тухайн төслөөр олсон амжилтаа бататгах, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд санхүүгийн ямар арга, эх үүсвэр ашиглах тухайгаа тайлбарлана. Үүндээ тухайн төсөл дууссаны дараа энэхүү ажил, санаачилгыг дэмжих нөөц бололцоо бий гэдгийг хандивлагчид нотлох ёстой.

9. Төсөв. Тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн тухай бүх мэдээллийг энэ бүлэгт тусгана. Энд төслийн хүрээнд хийх ажил, үйл ажиллагааны бүх зардлыг жагсааж, дараахь асуултын хариултыг бэлтгэсэн байвал зохино. Үүнд:

- Хандивлагчаас хичнээн хэмжээний санхүүжилт хүсэж байгаа
- Санхүүжилтийн үлдэж буй хэсгийг ямар эх үүсвэрээс олох
- Хөрөнгө чухам юунд зарцуулагдах

10. Хавсралт. Төслийн баримт бичигт захиалгын агуулгыг тодотгож, тайлбарласан нэмэлт мэдээлэл, материалыг хавсаргасан байна.